



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/182/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2/11

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D- alban bichig 2022 A4 TOOT

• 005020224

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,748,040.10	3,064,430.10
33	АВЛАГА	3,000,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,748,040.10	3,064,430.10
354	Хангамжийн материал	15,748,040.10	3,064,430.10
35410	Бичиг хэргийн материал	13,894,720.00	1,029,520.00
35420	Аж ахуйн материал	1,853,320.10	2,034,910.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,536,368.26	27,736,640.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,536,368.26	27,736,640.54
392	Биет хөрөнгө	24,536,368.26	27,736,640.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,000,000.00	-40,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,629,254.27	55,542,654.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,800,886.01	-28,442,013.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,489,730.00	6,489,730.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,781,730.00	-5,853,730.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	43,284,408.36	30,801,070.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,000,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,000,000.00	00.00
413	Өглөг	3,000,000.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,000,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	40,284,408.36	30,801,070.64
51	Засгийн газрын хувь оролцоо	40,284,408.36	30,801,070.64
512	Хуримтлагдсан үр дүн	40,284,408.36	30,801,070.64
51210	Өмнөх үеийн үр дүн	40,284,408.36	40,284,408.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,483,337.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	43,284,408.36	30,801,070.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	437,408,052.00	267,061,818.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,062,697.00	8,235,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,062,697.00	8,235,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,062,697.00	8,235,900.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	7,913,400.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	21,062,697.00	322,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,345,355.00	258,825,918.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	101,060,700.00	111,900,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	101,060,700.00	111,900,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,284,655.00	146,925,418.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	13,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,284,655.00	133,925,418.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	403,262,218.35	276,545,155.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,262,218.35	276,545,155.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,002,813.88	270,261,139.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,389,679.00	91,306,361.00
210101	Үндсэн цалин	56,354,579.93	61,336,444.00
210102	Нэмэгдэл	17,988,299.07	23,105,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	3,933,000.00
210104	Урамшуулал	4,467,600.00	2,930,980.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,484,109.53	11,863,995.00
210201	Тэтгэврийн даатгал	6,883,355.53	8,163,795.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,085,554.00	925,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	670,700.00	740,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	167,700.00	185,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,676,800.00	1,850,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,994,128.00	1,954,200.00
210401	Бичиг хэрэг	488,150.00	517,700.00
210402	Тээвэр, шатахуун	554,994.00	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	672,984.00	491,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	278,000.00	226,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	2,980,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	2,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,345,064.00	157,146,056.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,635,934.00	156,075,039.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	169,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,508,300.00	783,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,289,833.35	5,010,527.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	354,300.00	297,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,935,533.35	4,713,127.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,259,404.47	6,284,016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	190,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	190,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,013,404.47	6,094,016.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,683.47	1,850,437.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,145,833.65	-9,483,337.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,145,833.65	-9,483,337.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	416,345,355.00	261,825,918.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,345,355.00	261,825,918.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	101,060,700.00	111,900,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	101,060,700.00	111,900,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,284,655.00	149,925,418.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,284,655.00	133,925,418.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,000,000.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	412,363,355.00	261,825,918.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,363,355.00	261,825,918.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,103,950.53	255,541,902.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,839,199.07	91,841,964.00
210101	Үндсэн цалин	56,804,100.00	59,545,364.00
210102	Нэмэгдэл	17,988,299.07	23,429,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,399,800.00
210104	Урамшуулал	4,467,600.00	4,467,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,399,589.46	11,328,392.00
210201	Тэтгэврийн даатгал	6,798,835.46	7,628,192.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,085,554.00	925,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	670,700.00	740,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	167,700.00	185,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,676,800.00	1,850,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,477,794.00	2,183,390.00
210401	Бичиг хэрэг	541,400.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	844,994.00	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	627,400.00	533,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	417,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	304,553,568.00	146,887,756.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	303,394,338.00	145,813,139.00
210803	Даатгалын үйлчилгээ	199,830.00	180,617.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	85,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	874,400.00	787,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,800.00	300,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	333,800.00	300,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,259,404.47	6,284,016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	190,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	190,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,013,404.47	6,094,016.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,000,721.00	4,243,579.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,683.47	1,850,437.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,982,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,982,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,982,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,982,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,982,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,982,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,138,368.43	00.00	6,138,368.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	6,138,368.43	00.00	6,138,368.43
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	40,284,408.36	00.00	40,284,408.36
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	40,284,408.36	00.00	40,284,408.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	40,284,408.36	00.00	40,284,408.36
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-9,483,337.72	00.00	-9,483,337.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	30,801,070.64	00.00	30,801,070.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны төгрөгөөр			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,900,500.00	110,050,063.00	1,850,437.00	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,900,500.00	110,050,063.00	1,850,437.00	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,703,700.00	109,860,063.00	1,843,637.00	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92,506,200.00	91,841,964.00	664,236.00	99.3
210101	Үндсэн цалин	60,030,200.00	59,545,364.00	484,836.00	99.2
210102	Нэмэгдэл	23,429,200.00	23,429,200.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,399,800.00	179,400.00	96.1
210104	Урамшуулал	4,467,600.00	4,467,600.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,488,300.00	11,328,392.00	1,159,908.00	90.7
210201	Тэтгэврийн даатгал	8,788,100.00	7,628,192.00	1,159,908.00	86.8
210202	Тэтгэмжийн даатгал	925,100.00	925,100.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	740,000.00	740,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	185,000.00	185,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,850,100.00	1,850,100.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,183,400.00	2,183,390.00	10.00	100.0
210401	Бичиг хэрэг	514,300.00	514,300.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	718,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,300.00	533,300.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,600.00	417,590.00	10.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,225,400.00	1,205,917.00	19,483.00	98.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,300.00	131,300.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	180,617.00	19,383.00	90.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	85,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,100.00	22,000.00	100.00	99.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	787,000.00	787,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,400.00	300,400.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,400.00	300,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,800.00	190,000.00	6,800.00	96.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	190,000.00	6,800.00	96.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	190,000.00	6,800.00	96.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,900,500.00	110,050,063.00	1,850,437.00	98.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,900,500.00	110,050,063.00	1,850,437.00	98.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	111,900,500.00	110,050,063.00	1,850,437.00	98.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	төгрөгөөр
			Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	307283934.00	141,438,260.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307283934.00	141,438,260.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307283934.00	141,438,260.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307283934.00	141,438,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	307283934.00	141,438,260.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	307283934.00	145681839.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	307283934.00	145,681,839.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27000000.00	13,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	280283934.00	129,681,839.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 04 өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Үндэсний Статистикийн хорооны дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 403,262.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,048.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,234.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,683.6 мянган төгрөгөөр буюу 83.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,748.0	3,064.4	(15,683.6)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,000.0	-	(3,000.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	15,748.0	3,064.4	(12,683.6)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,536.4	27,736.6	3,200.3
Үндсэн хөрөнгө	94,569.0	102,482.4	7,913.4
Хуримтлагдсан элэгдэл	(70,032.6)	(74,745.7)	(4,713.1)
Нийт хөрөнгө	43,284.4	30,801.1	(12,483.3)
Өр төлбөр	3,000.0	-	(3,000.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	40,284.4	30,801.1	(9,483.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	43,284.4	30,801.1	(12,483.3)

Бараа материалын дансны үлдэгдэл 3,064.4 мянган төгрөг болж 12,683.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдэл Хүн ам орон сууцны тооллогын үр дүнгийн номыг аймаг, сумын байгууллагуудад тараасантай нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 102,482.3 мянган төгрөг болж 7,913.4 мянган төгрөгөөр өссөн нь Үндэсний статистикийн хорооноос олгосон тоног төхөөрөмжийг Тамгын газрын даргын 2021 оны 05 сарын 28-ны өдрийн албан бичгийн дагуу хөрөнгийн бүртгэлд бүртгэсэнтэй холбоотойгоор нэмэгджээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 30,801.1 мянган төгрөг болж 9,483.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 9,483.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 150,830.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 150,830.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 38,929.9 мянган төгрөгөөр бууруулж 111,474.8 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 111,900.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 111,900.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 111,900.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 110,050.0 мянган төгрөгийг зарцуулж 1,850.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 110,050.0 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь 12 дугаар сард 1 орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал 664.2 мянга, НДШ-ын хувь хэмжээнд 7 дугаар сард өөрчлөлт орсон болон орон тоо дутуу ажилласнаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1,159.9 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 19.3 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардал 6.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 133,925.4 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 13,000.0 мянга, өмнөх оны авлага 3,000.0 мянга нийт 149,925.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, Статистикийн тухай хуулийн дагуу ээлжит тооллого, судалгаанд зарцуулж 145,681.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,243.5 мянган төгрөгийг улсын төсөвт

төвлөрүүлжээ. Энэ нь 5 жил тутамд 1 удаа зохион байгуулдаг бичил уурхай эрхлэгчдийн тооллогын хамрах хүрээ төсөвлөсөн хэмжээнд хүрээгүй улмаас хэмнэгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 97.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 258,825.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 157,519.4 мянган төгрөгөөр буюу 37.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил зардал нэмэгдсэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 259,610.0 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн бөгөөд байршуулаагүй буюу хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	1		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	27	151	151		

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж аваагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____ оОо _____